



**ОРХОН АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2022 оны 08 сарын 24 өдөр

Дугаар 4/97

Эрдэнэт

Г Э Ээлжит хуралдаан зарлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3 дахь хэсэг, Улсын Их Хурлын 2022 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 07 дугаар тогтоолоор батлагдсан “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зөвлөлийн ажиллах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 8 дахь удаагийн сонгуулийн Ээлжит XI хуралдааныг 2022 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр Эрдэнэт хотод зарлан хуралдуулж, дараах асуудал хэлэлцүүлэхээр тогтоосугай.

- 1.1.Аймгийн 2021 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай
  - 1.2.Нэршил өөрчлөх тухай
  - 1.3.Зөвшөөрөл олгох тухай
  - 1.4.Хувьчлах жагсаалт батлах тухай
  - 1.5.Орон нутгийн өмчit хувьцаат компани байгуулах тухай
  - 1.6.Журам шинэчлэн батлах тухай
  - 1.7.Газрын үнэлгээний бүс, итгэлцүүрийн тоон утга, төлбөрийн хэмжээг тогтоох тухай
  - 1.8.Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө батлах тухай
- 2.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ээлжит XI хуралдааны бэлтгэл хангах арга хэмжээний төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.
- 3.Хуралдааны бэлтгэл хангах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллахыг Зөвлөлийн гишүүдэд даалгасугай.



C:\My documents\Zahiramj

079140167

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын  
2022 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн  
8/97 дугаар захирамжийн хавсралт

АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ЭЭЛЖИТ XI ХУРАЛДААНЫ БЭЛТГЭЛ ХАНГАХ  
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ээлжит XI хуралдааныг зарласан тухай аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид, Засаг дарга, холбогдох байгууллага, албан тушаалтан, иргэдийг мэдээллээр хангах;

ҮIII/25-ны дотор

Ажлын алба

2."Аймгийн 2021 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай", "Нэршил өөрчлөх тухай" шийдвэрийн төсөл боловсруулж ажлын албанд ирүүлэх, Хурлын зөвлөлийн болон хурлын хуралдаанд оруулж хэлэлцүүлэх;

IX/08, IX/12, IX/15-ны дотор

Аймгийн Засаг дарга С.Батжаргал

3."Зөвшөөрөл олгох тухай", "Хувьцаат компани байгуулах тухай", "Орон нутгийн өмчт хувьцаат компани байгуулах тухай" илтгэл, холбогдох тооцоо судалгаа, шийдвэрийн төсөл боловсруулж Ажлын албанд ирүүлэх, Хурлын зөвлөлийн болон хурлын хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх;

IX/08, IX/12, IX/15-ны дотор

Аймгийн Засаг дарга С.Батжаргал

4. Журам шинэчлэн батлах тухай илтгэл танилцуулга, шийдвэрийн төсөл боловсруулж Ажлын албанд ирүүлэх, Хурлын зөвлөлийн болон хурлын хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх;

IX/08, IX/12, IX/15-ны дотор

Аймгийн Засаг дарга С.Батжаргал

5."Газрын үнэлгээний бүс, итгэлцүүрийн тоон утга, төлбөрийн хэмжээг тогтоох тухай", "Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө батлах тухай" илтгэл, танилцуулга, холбогдох тооцоо судалгаа, шийдвэрийн төсөл боловсруулж Ажлын албанд ирүүлэх, Хурлын зөвлөлийн болон хурлын хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх;

IX/08, IX/12, IX/15-ны дотор

Аймгийн Засаг дарга С.Батжаргал

6.Хуралдаанаар хэлэлцэх асуудалтай холбогдуулан холбогдох хороод ажиллаж санал дүгнэлт гаргах;

IX/12-ны дотор

Холбогдох Хороод

7. Төлөөлөгчид тойрогтоо ажиллах, сонгогчидтой уулзах, хуралдаанаас гарах шийдвэрийн төсөлд тусгуулах санал асуудлыг нэгтгэж Ажлын албанд ирүүлэх;

IX/12-ны дотор

Төлөөлөгчид

8. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ээлжит XI хуралдааны бэлтгэл хангасан дүнг Хурлын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх, илтгэл илтгэгчийг батлах;

IX/12-ны дотор

Хурлын дарга Д.Мөнхбат

9. Техник зохион байгуулалтын бэлтгэл ажлыг хангах;

IX/15-ны дотор

Ажлын албаны дарга Д.Эрдэнэцэцэг

**АЖЛЫН АЛБА**